



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 14 өдөр

Дугаар А/307

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 01/2809 албан бичгийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцын 17.3.34-т заасан “Хадлан тэжээлийн нөөц бүрдүүлэх тоног төхөөрөмж” (Хөвсгөл) арга хэмжээний гүйцэтгэгч сонгох ХХААХҮЯ/2022212043 дугаартай гэрээний гүйцэтгэлийг хүлээн авах ажлын хэсгийг хавсралтаар байгуулсугай.

2. “Хадлан тэжээлийн нөөц бүрдүүлэх тоног төхөөрөмж” (Хөвсгөл) арга хэмжээний гүйцэтгэгчтэй техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэх гэрээг үндэслэн тоног төхөөрөмжийг хүлээн авч холбогдох бичиг баримтыг бүрдүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Я.Эрхэмбаяр)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын даргын 2022  
оны 09 дүгээр сарын 14-ны өдрийн  
А/307 дүгээр захирамжийн хавсралт

**“ХАДЛАН ТЭЖЭЭЛИЙН НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ ТОНОГ  
ТӨХӨӨРӨМЖ” ХҮЛЭЭН АВАХ АЖЛЫН ХЭСГИЙН  
БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: Я.Эрхэмбаяр  
(Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

Гишүүд: Д.Чинзориг  
(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн  
бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн  
мэргэжилтэн)

Ц.Бэхбаяр  
(Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Өмчийн  
мэргэжилтэн)

Э.Эрдэнэчулуун  
(Гүйцэтгэгч “Эм Ти Эм Жи” ХХК-ний захирал)

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Т.Пүрэвхүү  
(Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн  
албаны мэргэжилтэн)

--oOo--